

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОРОН НУТГИЙН ХУРЛЫН НӨХӨН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ НАМ ЭВСЭЛ, НЭР
ДЭВШИГЧИЙН СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАНГ ХЯНАЖ, НИЙТЭД МЭДЭЭЛЭХ

АУДИТЫН КОД: ХӨА-2022/19-15-НА-СТА

Хөвсгөл аймаг
2022 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх
аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: Tegshdelgerb@audit.gov.mn

Аудитор: З.Даваадорж

Утас: 89100230 Цахим хаяг: Davaadorjz@audit.gov.mn

Аудитор: Г.Ичинхорлоо

Утас: 88012671 Цахим хаяг: ichko.0808@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу.
https://audit.mn/?page_id=579

1. Аудитын нэр

Орон нутгийн хурлын нөхөн сонгуульд оролцох нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланг хянаж, нийтэд мэдээлэх.

2. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-д “Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага зардлын тайланг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хянаж, дүнг нийтэд мэдээлэх бөгөөд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлнэ.” гэж заасныг үндэслэн Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар нэр дэвшигчдийн сонгуулийн зардлыг тайланг хянаж баталгаажуулсан.

3. Аудитын зорилго

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцсон нам, эвслийн төвлөрүүлсэн орлого, иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандив, сонгуулийн зардлыг хянаж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, нийтэд мэдээлнэ.

4. Аудитын хамрах хүрээ

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцсон нам, эвслийн сонгуулийн зардлын тайланд хийсэн аудитын дүгнэлт, аудитын дэлгэрэнгүй тайлан, аудит хийгдсэн сонгуулийн зардлын тайлангийн маягтууд, харилцагч банкны дансны хуулга бусад шаардлагатай баримтуудыг хамарсан.

5. Арга зүй

Аудитын ажлыг гүйцэтгэхэд Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудиторов 2020 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлан гаргах, зардлын тайланд аудит хийх, хянах, дүнг нийтэд мэдээлэх, танилцуулах журам”-ыг үндэслэн нам, эвслээс оруулсан хөрөнгө, иргэн, хуулийн этгээдээс авсан хандив түүний зарцуулалтын тайланг шалгаж, аудит хийсэн хуулийн этгээд, нам, эвслээс лавлагаа, тодруулга авч, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж тайланг бэлтгэв.

6. Үндсэн мэдээлэл

Хөвсгөл аймгийн Галт, Тариалан, Түнэл сумын орон нутгийн хурлын нөхөн сонгуульд 3 тойрогт 6 нэр дэвшигч өрсөлдсөн байна.

Үүнд:

/Хүснэгт 1/

№	Нам, бие даан нэр	Нэр дэвшигч	Бие даагч
1	Монгол Ардын нам	2	
2	Ардчилсан нам	3	
3	Бие даагч		1
Нийт		6	

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудиторов 2020 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн А/16, А/17 дугаар тушаалаар аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, нэр дэвшигч, бие даагчаас зарцуулах зардлын дээд хэмжээг сум, баг бүрээр өөр өөр тогтоосон бөгөөд

зардлын дээд хэмжээ нь суманд 20.5 сая төгрөг, багт 8.5 сая төгрөг байхаар баталсан.

7. Сонгуулийн зардлын тайлан ирүүлсэн байдал

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд нэр дэвшигчдээс МАН-ын 3 нэр дэвшигч, АН-ын 2 нэр дэвшигч, нийт 5 нэр дэвшигч хуулийн хугацаанд сонгуулийн зардлын тайлан, аудитын дүгнэлтийг ирүүлж, бие даан нэр дэвшсэн 1 нэр дэвшигч хуулийн хугацаанд сонгуулийн зардлын тайлан, аудитын дүгнэлтийг ирүүлээгүй байна.

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нөхөн сонгуульд нэр дэвшигчид нийт 5,410.0 мянган төгрөгийн хандивыг хүлээн авч зарцуулсан байна. Нэр дэвшигчдийн авсан хандивыг задлан харуулбал:

/Хүснэгт 2/

№	Нэр дэвшигчийн нэр	Хандивын дүн /мянган төгрөг/
1	Ц.Хөвсгөлдалай	4,680.0
2	Ж.Самбаллхүндэв	300.0
3	Л.Даваадорж	430.0
	Нийт	5,410.0

Сонгуульд оролцсон нэр дэвшигч, бие даагч нь зардлын дээд хэмжээнд багтаан зардал гаргасан байна. Нэр дэвшигч Л.Цэнд-Аюуш, Б.Зуунжил нар нь хандив аваагүй, сонгуулийн зардал гаргаагүй байна. Цаашид аймгийн Сонгуулийн хороо нь сонгуульд оролцож буй нам, нэр дэвшигч нарт сонгуулийн зардлын дансыг нээлгэж, зардлын дансанд мөнгөн хөрөнгийг төвлөрүүлж, зарцуулах талаар зөвлөмжийг хүргүүлж ажиллах нь зүйтэй байна.

8. Хуулийн дагуу мэдээлэх хандив

Сонгуулийн зардлын тайланг хянан баталгаажуулах Төрийн аудитын байгууллага нь аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1¹-д заасны дагуу нам, нэр дэвшигч бие даагчид нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлэх үүрэгтэй.

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцсон нэр дэвшигчдэд иргэдээс өгсөн нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандивыг харуулбал:

/Хүснэгт 3/

№	Хандив өгсөн иргэн, хуулийн этгээдийн нэр	Хандив хүлээн авсан нэр дэвшигч	Хандивын дүн /мянган төгрөг/
1	Ц.Гансүх	Ц.Хөвсгөлдалай	1,000.0
2	Х.Отгонцэцэг	Ц.Хөвсгөлдалай	1,000.0
	НИЙТ		2,000.0

9. Хуулиар зөвшөөрөгдөөгүй хандив:

Аймаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оролцсон нэр дэвшигчдэд иргэдээс өгсөн хандивыг хянан үзэхэд хуулиар хүлээн зөвшөөрөгдөөгүй хандив аваагүй байна.

10. Сонгуулийн зардлын тайланд хийсэн аудитын илрүүлэлт:

¹ Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага ...дүнг нийтэд мэдээлэх бөгөөд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлнэ.

Орон нутгийн хурлын нөхөн сонгуулийн зардлын тайланг хянаж үзэхэд дараах зөрчлүүд илэрлээ.

- Сонгуулийн зардлын тайлангаа ирүүлээгүй 1 бие даан нэр дэвшигч байна.

11. Аудитын дүгнэлт

1. Аймаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд нэр дэвшигчдээс 5 нэр дэвшигч хуулийн хугацаанд сонгуулийн зардлын тайлан, аудитын дүгнэлтийг ирүүлж, бие даан нэр дэвшсэн 1 нэр дэвшигч хуулийн хугацаанд сонгуулийн зардлын тайлан, аудитын дүгнэлтийг ирүүлээгүй байна.
2. Орон нутгийн нөхөн сонгуульд оролцсон нэр дэвшигчид нийт 5,410.0 мянган төгрөгийн хандив цугларснаас хуулийн дагуу нийтэд мэдээлэх 2,000.0 мянган төгрөгийн хандив байна.

Зөвлөмж

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн, Нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагч Т.Энхтуяа-д:

1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3 дах заалтын дагуу сонгуулийн зардлын тайланг ирүүлээгүй нэр дэвшигчид Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 17.1.25² дах заалт, Зөрчил хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 1.8.6.22³ дах заалтын дагуу арга хэмжээ авч ажиллах

² Нам, эвсэл, нэр дэвшигч нь сонгуулийн зардлын тайлангаа хуульд заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хүргүүлэх үүргээ биелүүлээгүй бол хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

³ нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 9.4 дүгээр зүйлийн 1, 5 дахь хэсэг, 9.8 дугаар зүйл, 9.10 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 11.1 дүгээр зүйл, 11.10 дугаар зүйлийн 14 дэх хэсэг, 11.13 дугаар зүйл, 11.18, 11.20, 11.25, 11.27 дугаар зүйл, 17.1 дүгээр зүйлийн 25, 27 дахь хэсэгт заасан зөрчил;



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ТУШААЛ**

2022 оны 09 сарын 08 өдөр

Дугаар А/Б

Мөрөн сум

Аудитын тайлан батлах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.4, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Орон нутгийн хурлын нөхөн сонгуульд оролцох нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланг хянаж, нийтэд мэдээлэх” нийцлийн аудитын тайланг баталсугай.

2. Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нөхөн сонгуульд оролцсон нэр дэвшигчид нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэдийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

3. Аудитын тайлан болон нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэдийн жагсаалтыг www.audit.mn цахим хуудсаар нийтэд мэдээлж, аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер /Б.Тэгшдэлгэр/-д даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 1/13 тоот тушаалын хавсралт

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нөхөн сонгуульд оролцсон нэр дэвшигчид нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэдийн жагсаалт

/мянган төгрөг/

д/д	Хандив өгсөн иргэн, хуулийн этгээдийн нэр	Хандив хүлээн авсан нам, нэр дэвшигч, бие даан нэр	Хандивын дүн /мянган төгрөг/
1	Ц.Гансүх	Ц.Хөвсгөлдалай	1,000.0
2	Х.Отгонцэцэг	Ц.Хөвсгөлдалай	1,000.0
НИЙТ			2,000.0